



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/87

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумдын айл өрхийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэхэд шаардлагатай зохион байгуулалтыг хийж, Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Дархантөр	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
Нарийн бичиг:	Б.Мөнхжаргал	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Ч.Ариунаа	БЗӨБЦТСС-ын Хэнтий аймаг дахь салбарын дарга
	Х.Баярбаатар	Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
	Г.Баярцэцэг	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн

2. Дээрх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу удирдан зохион байгуулж, үр дүнг аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлд танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Дархантөр/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ

231010256